

**МОНГОЛЧУУД БИД ЭНЭ ХҮНИЙ ДУРСГАЛЫГ ХҮНДЭТГЭЖ,
МӨНХЖҮҮЛЭХ УЧИРТАЙ ЮМАА**

Монгол Улсаас ОХУ-д суугаа Элчин
Сайдын яамны зөвлөх Батжаргалын
Жамбалдоржийн дурсамж яриа

1991 -1993 онуудад би Ленинград (эдүгээгийн Санкт-Петербург) хотноо Монголын Элчин сайдын яамны төлөөлөгч хэмээх дипломатын түүхэнд байхгүй өвөрмөц албан тушаалыг хашсан билээ. Намайг тийш очиход Элчин зөвлөх Жаргалсайханы Энхсайхан:

-Жамбалдорж оо, чи Оросын дорно дахины нэрт судлаач эрдэмтэн Лев Николаевич Гумилев гуайтай танилцаж, холбоо тогтоох хэрэгтэй гэж захьсан юм. Би Ленинградод очоод тун удалгүй сайхь эрдэмтний гэрийн утсыг олж, залгахад гэргий нь авав. Тэднийд өмнө нь олон монголчууд очиж элдэвийг ярьж залхаачихсан, тэгээд ч бие нь тааруу байгааг сонссон учир би өөрийгөө танилцуулаад, яриагаа тун холоос эхэлж, Ленинградод миний аав, ээж суралцаж, эрдмийн зэрэг хамгаалж байсан тухай, Орос орны цаг үеийн байдлын тухай ярьж, харилцан элдвийг хүүрнэлээ. Бараг л цаг шахам ярьсан байх. Тэгтэл тэрбээр:

-Та ер нь манай Левтэй ярь гээд харилцуураа шилжүүлсэн юм. Бид товчхон яриад, очиж уулзахаар болов. Байшинг нь заалгаж авлаа. Харин надад тун уриалагхан хандсан шүү. Очоод хашаачаас нь асуусан чинь:

-Тэр цонх гэж зааж өгөв. Ингэж л би тэр алдарт эрдэмтэнтэй танилцаж, тэднийхээр орж гардаг болсон юм. Тэр үед юм ховор, хиам, бяслаг зэрэг нь нандин хүнсэнд орж байлаа шүү дээ. Би Консулын дэлгүүрээр орж, Гумилев гуайнд хүнсний зүйл аваачиж өгнө, хоёр хөгшин их баярладаг байсан юм.

Тэднийх хоёр, гурван жижиг өрөөтэй айл байлаа. Өөрийнх нь ажлын өрөөнд нэгэн эмэгтэйн нас барсных нь дараа нүүрнээс нь авсан гипсэн хэв байсан. Би:

-Энэ танай ээжийн нүүрний хэв үү? гэж асуухад Гумилев гуай:

-Тиймээ, миний ээж Анна Ахматова бол Зүчийн удмын хүн гэж хэлж байсан. Өөрийхнөө амьдрал болон аав, ээжийнхээ намтар цадигийг их ярьдаг байсан. Гумилев гуай бүтэн 15 жилийг “хар гэр”-т өнгөрөөсөн хүн аж. Эхлээд эсэргүү эцгийн хүү гээд дахиад таван жил, дараа нь ер нь чи бол тэрс үзэлтэн гээд таван жил хорих газар өнгөрөөсөн гэж ярьж байсан. Хоригдож байхдаа ойр орчныхоо хүмүүст үргэлж Чингис хааны тухай ярьж байсан учраас намайг Чингис гэж нэрлэх болсон гэж хуучилж байж билээ. Хожим ч энэ нэрээр хүмүүс дуудаж байсан учир би заримдаа гарын үсгээ Чингис гэж зурдаг гэж ярьж байсан.

Нэг удаа би:

-Та яагаад монголчуудад 500-хан жилийн нас өгөөд байгаа юм бэ? гэж асуухад өвгөн:

-Улс гүрэн бол амьд эд эс. Та нар XIII-XIV зуунд ухаан чадлынхаа дээд цэгтээ хүрсэн. Орос бол залуу гүрэн. Угтаа Оросыг монголчууд улс болгосон. 500 нас өгсөн нь харьцангуй ойлголт. Архин далайд живэхгүй, залхуурахгүй, эв түнжинтэй, ухаалаг, ажилсаг байж чадвал монголчууд мянга, хэдэн мянган жил ч оршин тогтноно шүү дээ гэж хэлж билээ. Бас нэг удаа ярьж байгаад:

-XIII зуунд сансараас хүчтэй эрчимт туяаны тусгал Монголын нутагт туссан. Энэ тусгалыг хүлээж авсан зон олон бусдаас хэд дахин ухаалаг, эрчимлэг, чадалтай болдог. Үүний үрээр монголчууд дэлхий дахиныг эрхэндээ оруулсан гэхэд би ойлгоогүй хэт хийсвэр сэтгэлгээ гэж бодоод өнгөрсөн. Одоо бодоход “пассионарность”-ийн тухай ярьж байсан хэрэг байж. Мөн “Этногенез и биосфера Земли” бүтээлээрээ докторын зэрэг

IV. ТҮҮХЭН ХҮН СУДЛАЛ, НАМТАР СУДЛАЛЫН АСУУДЛУУД

хамгаалах гэж газар зүйн эрдэмтдэд хандахад түүхийн сэдэв байна гэжээ. Түүхчдэд хандахад манайд хамаарахгүй гээд хүлээж авах газар олноогүй хэмээн дурсан ярьж байсан билээ.

Гумилев гуай залуудаа цэргийн алба хаасан гээд манаа, харуулд гараад зарим шөнө унтаж, үүрэглэхгүйн тулд францаар шүлэг уншиж нойроо сэргээдэг байжээ. Тэрбээр франц, англи болон бусад хэд хэдэн хэл мэддэг байсан юм билээ.

Би нэг удаа:

-Та насаараа монголыг судаллаа. Монголд очиж үзээгүй байдаг. Таныг урьж байна гэхэд тэрбээр:

-Залуу, идэр үед маань та нар намайг хүлээж аваагүй. Одоо замын ая даахгүй болж дээ гэж байсан.

Би Лев Гумилев гуайн тухай телевизийн нэвтрүүлэг хийх ажлыг зохион байгуулсан. Москвад сууж байсан Монголын радио, телевизийн сурвалжлагч Ч.Түмэндэлгэр сайхь эрдэмтэнтэй хөөрөлдөж, зураглаач Бямбадорж зураг авсан. Өвгөний бие тааруу байсан учир эхнэр нь удаан ярьж болохгүй, хорь, гучин минутаас хэтрүүлэхгүй ажлаа амжуул гэсэн нөгөө хоёр маань ядаж нэг цаг ярилцах сонирхолтой байлаа. Ийм учраас би хөгшинтэй нь гал тогооны өрөөнд элдвийг ярьж саатуулаад цаг гаруй зураг авсан. Тэр нэвтрүүлэг Монгол телевизээр хэд дахин явсан гэсэн. Энэхүү бичлэг Монголын үндэсний телевизийн алтан фондод үлдэнд би сэтгэл өгч байдаг юм.

Лев Гумилев гуай 1992 оны VI сарын 15-нд хан хорвоогоос хальсан. Түүний шарилыг Газар зүйн нийгэмлэгийн хүндэтгэлийн их танхимд байрлуулж салах ёс гүйцэтгэсэн. Хотын дарга А.А.Собчакийн зөвшөөрлөөр их эрдэмтнийг Невийн Александрын бунхан бүхий Никольскийн оршуулгын газар оршуулсан.

Оршуулах ёслолд би, гэргий Б.Цэсмаагийн хамт оролцож, ОХУ-д суугаа Монгол Улсын Элчин сайдын нэрийн өмнөөс эмгэнэлийн үгтэй цэцгэн эрхи өргөж, эхлээд Оросын ШУА-ийн төлөөлөгч, дараа нь өөрийнх нь шавь үг хэлсэн. Гэтэл Гумилев гуайн гэргий монголын төлөөлөгч Жамбалдоржоор үг хэлүүлье гээд би үг хэлсэн. "Таныг монголын ард түмэн сайн мэддэг, гүнээ хүндэтгэдэг, Та бол насан турш Монголын түүх, соёлыг судлаж, монголчуудыг хайрлаж, хамгаалж, өмгөөлж ирсэн их түүхч эрдэмтэн байлаа. Монголчуудынхаа өмнөөс гүн эмгэнэл илэрхийлье" гэсэн утгатай зүйл хэлсэн юм даг. Ийм үед үг хэлэх хэцүү юм билээ, хоолой зангирч, аньсага нурууд. Миний дараа Франц, Гүрж, Арменийн албан ёсны төлөөлөгчид үг хэлж байсан. Аль улс нь билээ, одонгоор шагнаснаа гардуулж амжаагүй гээд эхнэрт нь өгч байсан.

Манай Монголд Лев Николаевич Гумилевийг сайн сурталчлахгүй л байх шиг, түүний дурсгалыг мөнхжүүлэх учиртай ард түмний нэг бол монгол яах аргагүй мөн. Казахстанд нэг их сургуулийг Гумилевийн нэрэмжит болголоо. Түүний нэрэмжит фондууд Оросод болон бусад орнуудад бий болж байна. Түүнийг амьд сэрүүнд Монголын төр, засаг сэтгэлийг нь зөөллөх үг хэлж чадаагүй юм, одоо нэгийг бодох цаг болсон болов уу хэмээн мунхагланам.

Жич: Б.Жамбалдорж бол их эрдэмтэн Л.Гумилевтай хамгийн сүүлд уулзсан монгол хүн болой.

Тэмдэглэсэн

Ж.Болдбаатар